


|                                                                                                                                                 |       |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------|
| ✓ Төслийн товч танилцуулга.....                                                                                                                 | 2-5   |
| ✓ Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл .....                                                                                                 | 6-8   |
| ✓ Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, зорилт .....                                                                                           | 9     |
| 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....                                                                                   | 10-11 |
| 2. Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө .....                                                                                           | 12    |
| 3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө. ....                                                                                          | -     |
| 4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө. ....                                                                       | -     |
| 5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө. ....                                                                                 | 13    |
| 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө. ....                                                                                                 | 13-14 |
| 7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө .....                                                                                                  | 15    |
| 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....                                                                                                     | 16    |
| 9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө. ....                                                                                               | 17    |
| 10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь ..... | 17    |
| 11. 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв.....                                                                                | 18    |
| 12. Холбогдох бичиг баримт.....                                                                                                                 | 19-   |

## БҮЛЭГ 1. ТЕХНИКИЙН БУС ХУРААНГУЙ


### 1.1 Төслийн талаарх мэдээлэл

#### Хүснэгт 1. Төслийн ерөнхий танилцуулга

| Нэг. Ерөнхий мэдээлэл          |                                                         |                                                                                                                                                                                                                                                        |
|--------------------------------|---------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1.1                            | Төсөл хэрэгжүүлэгч:                                     | “Бласт” ХХК<br>“Тэсрэх бодисын хольцын үйлдвэр, агуулахын цогцолбор” төсөл                                                                                                                                                                             |
| 1.2                            | Регистрийн дугаар:                                      | РД: 2688336                                                                                                                                                                                                                                            |
| 1.3                            | Улсын бүртгэлийн дугаар:                                | УБД: 9011125047                                                                                                                                                                                                                                        |
| 1.4                            | Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:                             | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Ланд Марк Утас: 325995, 324044                                                                                                                                                      |
| 1.5                            | Газар эзэмших эрхийн гэрчилгээ:                         | “Бласт” ХХК -д Сумын Засаг даргын 2009 оны 04 сарын 23-ны өдрийн А/191 тоот захирамжаар 60 жил олгосон 20000 мкв газрыг эзэмших эрхийн гэрчилгээ                                                                                                       |
| 1.6                            | Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ                       | Стандарт хэмжил зүйн газрын 2021 оны 03 сарын 24-ны ӨМД0001298 тоот шийдвэр бүхий “энгийн тэсрэх бодис ANFO, задгай технологийн эмульсийн тэсрэх бодис-blemex bulk, задгай технологийн эмульсийн тэсрэх бодис-blemex blend” төрлийн тохирлын гэрчилгээ |
| 1.7                            | Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл                        | Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яамны 2022 оны 12 сарын 23-ны өдрийн №864 тоот тусгай зөвшөөрөл                                                                                                                                                         |
| 1.8                            | Химийн бодисын тусгай зөвшөөрөл                         | БОАЖЯ-ны Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын албаны 2024 оны 12-р сарын 30-ны өдрийн дугаар 0000051 тоот зөвшөөрөл. 33 төрлийн бодис                                                                                               |
| 1.9                            | Химийн аюултай бодис, сав баглаа зайлуулах устгах гэрээ | “Түмэн эгшиг” ХХК-ийн 2024 оны гэрээтэй                                                                                                                                                                                                                |
| Хоёр. Төслийн талаарх мэдээлэл |                                                         |                                                                                                                                                                                                                                                        |
| 2.1                            | Төслийн нэр                                             | “Бласт” ХХК-ийн Дорноговь аймгийн Мандах сумын нутагт хэрэгжүүлэх гэж буй “Тэсрэх бодисын хольцын үйлдвэр, агуулахын цогцолбор” төсөл. <b>Тус цогцолбор нь шинээр байгуулагдаж байгаа бөгөөд бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж байгаа.</b>            |

|     |                 |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
|-----|-----------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 2.2 | Төслийн байршил | <p>Төслийн байршил нь Улаанбаатар хотоос зүүн урагш 500 км, Мандах сумаас урд зүгт 55 км зайд Дорноговь аймгийн Мандах сумын 1-р багийн нутагт байрлана.</p> <p>Газрын байршил нь үйлдвэрлэлийн районд оршдог бөгөөд орон сууц, олон нийтийн байгууламж бүхий хэсгээс 500м-ийн зайд байрладаг нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS 5105:2001 стандартын шаардлагыг хангаж байна.</p>  |
| 2.3 | Төслийн зорилго | <p>Тус үйлдвэр нь савлагаатай эмульсийн тэсрэх бодисын өндөр хүчин чадал бүхий шинэ шугам нэмж ашиглалтанд оруулан үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, урт хугацаанд хадгалах тээвэрлэхэд тохиромжтой савлагаатай энгийн болон эмульсийн тэсрэх бодисоор хэрэглэгчдэд тасралтгүй тогтмол нийлүүлэх, бүтээн байгуулалтын төслүүдэд хувь нэмэрээ оруулах зорилгоор энэхүү төслийг хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна.</p>                                                                                                                      |
|     |                 |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |



|     |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
|-----|---------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 2.6 | Төслийн хог хаягдал | <p>Бусад хог хаягдал: Үнс, түргэн муудах хоол хүнсний хаягдал, ариун цэврийн хэрэглэлийн хаягдал, дахин ашиглах хог хаягдлын ангилалд ороогүй бусад хог хаягдлууд</p> <p>Ахуйн аюултай хог хаягдал: Өөрөө явагч тээврийн хэрэгслээс үүсэх хаягдал</p> <p>/ашигласан тос, масло, үл хөлдөх шингэн, дугуй/ унтраалга-залгуурын төхөөрөмж, өдрийн гэрэл, электрон барааны хаягдал /компьютер, телевизор% гар утас/ цэвэрлэгээний бодис, зарим тусгай батерей зэргүүд хамаарна.</p> <p>Доорхи зургийн дагуу ялгаж хаях шаардлагатай</p>                                                                                                     |
|     |                     | <p>Шингэн хог хаягдал:</p> <p>Нийт 120 ажилтантай гэж үзвэл хоногт 9.6 м3, жилд амралт баяр ёслолын өдрийн хасаад 350 хоног ажиллах хугацаанд нийт хэрэглэх усны хэмжээ 3360 м3/жил болно. Төвлөрсөн цэвэр бохирын системд холбогдоогүй болно. Бага оврын цэвэрлэх байгууламж байгуулна.</p> <p>Хийн хаягдал:</p> <p>Үйлдвэрийн хийн хаягдал үүсэх эх үүсвэрүүд гэвэл автомашины утаа, тээврийн хэрэгслийн тоосжилт зэрэг байна.</p> <p>Үйлдвэрийн ашиглалтын 5 жилийн хугацаанд нийт 1481.7 тн /жилд 493.9 тн/ дизель түлш зарцуулахад хөө – 22.96 тн, СО-0.000148 тн, нүүрстөрөгч– 0.000445 тн, NO2–</p> <p>0.00005927 тн, SO2-0.00002963тн, бензопирин-0.000474 тн буюу нийтдээ 22.96 тн хорт хий ялгарахаар байна.</p> |

## **ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ**

Төслийн хэрэгжилтээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байгалийн хам бүрдэл тус бүрийн хувьд дэлгэрүүлэн авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Агаар орчинд үзүүлэх нөлөөлөл
- Хөрсөн бүрхэвч болон газрын хэвлийд үзүүлэх нөлөөлөл
- Усан орчинд үзүүлэх нөлөөлөл
- Ургамлан нөмрөгд үзүүлэх нөлөөлөл
- Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл
- Ажилчдын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

Төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээнээс харахад байгаль орчинд төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх гол сөрөг нөлөөллийг тодорхойлбол:

- Химийн бодис хадгалах агуулахын ойр орчим хог хаягдал ил задгай хаях, бодис асгаралтаас хөрс, усанд бохирдол тархах;
- Үйлдвэрийн үйл явцын үед аюулгүй байдал алдагдсанаас хөрс, агаар, усанд нөлөөлөх;
- Автомашин, тээврийн хэрэгслийн дуу чимээ нэмэгдсэнээр ан амьтан дайжих, байршил тархалт нь өөрчлөгдөх, амьдрах орон зай нь хумигдах;
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэх, үүнээс хөрс дагтарших, эвдрэх, ургамал нөмрөг доройтолд орох, улмаар хөрсний үржил шимт хэсэг устаж алга болох, механик бүрэлдэхүүн өөрчлөгдөх.

### **Экосистемийн өөрчлөлт**

“Тэсрэх бодисын хольцын үйлдвэр, тэсрэх материалын агуулах” төслийн барилга байгууламжуудыг барьж байгуулахад экосистемийн бүрэлдэхүүн хэсэгүүдэд сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Төслийн үйлдвэрлэл ба унд-ахуйн хэрэгцээнд газрын доорх усны нөөц баялгийг ашиглана. Төслийн үйл ажиллагааны явцад бий болох ихэнх нөлөөлөл нь шууд бус нөлөөлөлд хамаарна. Төслийг хэрэгжүүлэхэд тухайн орон нутгийн байгаль-экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох хөрс, ургамлан нөмрөг, газар, газрын доорхи усны нөөцөд шууд дунд зэрэг сөргөөр нөлөөлнө.

### **Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:**

Төслийн явцад агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл нь автомашины утаа, санамсар болгоомжгүйгээс үүссэн химийн бодисын алдагдал үүнээс үүсэх хийн хагядал, тоосжилт байх боломжтой юм. Тоосжилтын эх үүсвэрүүд нь:

- Автобаазын агуулахын засвар үйлчилгээ, тохижилтын ажлын үед
- Түүхий эд, эцсийн бүтээгдэхүүн ачиж буулгах, бэлдэх талбай дээрх машин механизмын хөдөлгөөн, дуу чимээ
- ШТС агуулах, ШТМ алдагдах агаарын чанар
- Химийн бодис тээвэрлэж буй машинаас асгарч болох шороо тоос

Төслийн талбайд ажиллаж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь тухайн орон нутгийн тоосжилтийн түвшинг нэмэгдүүлэх нэг эх үүсвэр болох бөгөөд агаарт дэгдэж буй тоосны улмаас үзэгдэх орчин багасаж осол, аваар гарч болзошгүй. Тоосжилтын улмаас төслийн ажилчид, ойр орчмын иргэдийн эрүүл мэнд болон эргэн тойрны байгаль орчинд зохих хэмжээгээр нөлөөлөх учир төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор үүсч буй тоосжилтийг бууруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Төсөл хэрэгжих орчин нь өнөөгийн байдлаар хүн, амьтан, ургамалд нөлөөлөхүйц биш алслагдмал зайтай байна.

### **Усан орчинд үзүүлэх нөлөөлөл:**

Усны хэрэглээ ба шингэн хаягдал: Ажилчдын ахуйн хэрэглээ болон цайны газраас хоногт хаягдах ахуйн бохир шингэн хаягдал гарна. Нэг хүний усны хэрэглээний нормыг 2015 оны 7 сарын



30 ны өдөр батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах норм” –ыг үндэслэн төслийн нийт ажилчид 120 хүн гэж тооцвол хоногт 1 ажилчин дунджаар 80 л ус ашиглана..

Төслөөс тухайн нутгийн гадаргын болон газрын доорх усанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Төслийн үйл ажиллагааны үед хөрсний болон газрын гадаргын усны нөөц, түүний чанарт үзүүлэх гол сөрөг нөлөөллүүд нь хаягдал бохир ус болон, шатах, тослох материалын хаягдлаар бохирдож болзошгүй;
- Машин механизмын зүй бус ашиглалтаас бензин, дизель болон бусад хорт бодис гоожих эсвэл алдагдсан нөхцөлд хөрс, орчмын ургамлын бүрхэвчид сөргөөр нөлөөлж улмаар хөрсөнд нэвчин гүний усыг бохирдуулах болзошгүй;
- Химийн бодис асгарах, алдагдах, химийн бодисын хаягдал, бодисын сав баглаа боодлыг зохих журмын дагуу устгалгүй, ил задгай хаяснаас үүдэн гадаргын болон газрын доорх ус бохирдож болзошгүй;
- Химийн бодисын ашиглалт, тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсанаас болон байгалийн гэнэтийн аюулт үзэгдлийн улмаас химийн хорт бодисоор гадаргын болон газрын доорх ус бохирдож болзошгүй.

#### **Хөрс, ургамлан бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл**

Төслийн үйл ажиллагаатай холбоотой машин техникийн нөлөөгөөр элэгдэл эвдрэлд орсноос зам дагуу тоосжилт ихэссэнээр ургамлан нөмрөг тоосжиж талхлагдахаас гадна хөрс, ургамлан бүрхэвчид дараах шууд болон дам сөрөг нөлөөлөлд өртөх магадлалтай байна. Үүнд:

- Үйлдвэр, агуулах цогцолборын машин техник, хүнд механизмуудын зогсоол зэрэг газарт хөрс ургамал талхлагдах, шатах тослох материал, хог хаягдлаар орчин, хөрс бохирдох;
- Барилгын ажлын явцад салхи, шуурганы нөлөөгөөр өнгөн хөрсний тодорхой хэсэг алдагдах;
- Химийн бодисын сав баглаа боодлыг зохих журмын дагуу устгалгүй, ил задгай хаяснаас хөрс бохирдох;
- Химийн бодисын ашиглалт, тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсанаас болон байгалийн гэнэтийн аюулт үзэгдлийн улмаас химийн хорт бодисоор ургамлан бүрхэвч бохирдож болзошгүй.

#### **Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл:**

Тус төслийн талбай нь амьтны аймгийн хувьд төрөл зүйл аль хэдийн байгалийн нутагшил, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдаж зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад байгаа болно. Төслийн барилга байгууламжийг барих үед машин, техникийн нөлөөгөөр үүсэх дуу чимээний нөлөөллөөс шалтгаалан тухайн орчны амьтад үргэн дайжиж, амьтадын орон зайн өөрчлөлт бий болох, дараа нь үйл ажиллагааны явцад хатуу хог хаягдал болон шингэн хаягдлыг зөв байршуулаагүй дүүрсэн тохиолдолд зайлуулахгүй удаах зэргээс болж орчны хөрс бохирдож улмаар хөрсний бичил организмууд хордох зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй байна.

#### **Түүх, соёлын дурсгалт зүйлст үзүүлэх нөлөөлөл:**


Тухайн төсөл хэрэгжих талбай болон ойр орчим ямар нэгэн түүхийн дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Иймд энэхүү төслийн үйл ажиллагаанаас түүх, соёлын дурсгалт зүйлс болон археологийн олдворт ямар нэгэн байдлаар нөлөөлөл байхгүй. Гэвч төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх, соёлын дурсгалт зүйл олдох аваас холбогдох хууль

тогтоомжид заасны засаг захиргааны анхдагч нэгж болон холбогдох байгууллага болох ШУА-ын Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж, төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

**Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хувьд:**

Төсөл хэрэгжихээр төлөвлөж буй талбай нь Дорноговь аймгийн Мандах сумын нутагт байрлах бөгөөд УТХГН-ын сүлжээтэй давхцаагүй байна. Төслийн талбайд хамгийн ойр орших хамгаалалттай газар нь, Арван наймын Богд уулын БНГ (40 км), Сүйхэнт уулын ДГ (40 км)-ууд байна.

УТХГН-ын сүлжээ



**Нийгэм эдийн засгийн хувьд үйлдвэрийн байршлын хувьд суурьшлын бүсэд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Тус үйлдвэр нь Дорноговь аймгийн Мандах сумын 1-р багт байрладаг бөгөөд орон сууц олон нийтийн байгууламж бүхий хэсэг нь 500 м-ийн зайд үйлдвэрийн бүсэд байрладаг. Үйлдвэрийн байршлын хувьд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS 5105:2001 стандартын шаардлагыг хангаж байна.



## **БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх эрх зүйн баримт бичиг юм.

“Бласт” ХХК-ийн Дорноговь аймгийн Мандах сумын 1-р багийн нутагт хэрэгжүүлж буй “Тэсрэх бодисын хольцын үйлдвэр, агуулахын цогцолбор” төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А618 тоот тушаал, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, 2012 оны 5 сарын 17-ны өдрийн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ 02 САРЫН 08-НЫ ӨДРИЙН 58 ДУГААР ТОГТООЛЫН 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 2-р хэсэгт тусгасны дагуу, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд тулгуурлан боловсруулав.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Бласт” ХХК -ийн заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Хүснэгт 21. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

| №                                                                                                  | Гол болон болзошгүй сөрөг         | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ                                                                                | Сөрөг нөлөөллийн хамрах | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ, мян.төг | Нийт зардал, мян.төг | Хугацаа, давтамж | Баримтлах хууль, журам, стандарт                                                     |
|----------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|-------------|------------|--------------------------|----------------------|------------------|--------------------------------------------------------------------------------------|
| Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ        |                                   |                                                                                                                                |                         |             |            |                          |                      |                  |                                                                                      |
| 1                                                                                                  | Агаарын бохирдол                  | Агаар дахь тоосжилтыг хэмжих, шинжилгээ хийлгэх                                                                                | Агаар орчин             | Ширхэг      | 1          | ОХШХ тусгасан            |                      | 2025 онд         | Агаарын тухай хууль                                                                  |
| 2                                                                                                  |                                   | Тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоонд тогтмол хамруулах                                                                        | Агаар орчин             | Ширхэг      | 1          | Үйл ажиллагааны зардал   |                      | 2025 онд         | Агаарын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль<br>MNS 4585:2016 |
| 3                                                                                                  |                                   | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтыг бууруулахад хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэх, тэмдэг тэмдэглэгээ байршуулах. | Агаар орчин             | Тогтмол     |            | Үйл ажиллагааны зардал   |                      | 2025 онд         |                                                                                      |
| Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ           |                                   |                                                                                                                                |                         |             |            |                          |                      |                  |                                                                                      |
| 4                                                                                                  | Усан орчин бохирдох, Зөвшөөрөлгүй | Ус ашиглалттай холбоотой дүгнэлт, гэрээ, зөвшөөрөл авч ажиллах                                                                 | Гүний худаг             | -           | -          | Үйл ажиллагааны зардал   |                      | 2025 онд         | “Усны тухай хууль” Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль                             |
| 5                                                                                                  | ус ашиглах, усны нөөц ашигласны   | Холбогдох байгууллагаас хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл авч ажиллах                                                            | Хаягдал ус              | Ширхэг      | 1 удаа     | Үйл ажиллагааны зардал   |                      | 2025 онд         |                                                                                      |
| 6                                                                                                  | төлбөр төлөгдөхгүй байх           | Усыг зохистой ашиглах, гүний усны талаар ажилчдад мэдээлэл өгөх                                                                | Нийт ажилчид            | Ширхэг      | 1-2 удаа   | -                        |                      | 2025 онд         |                                                                                      |
| Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ |                                   |                                                                                                                                |                         |             |            |                          |                      |                  |                                                                                      |

|                                                                                                    |                                                                         |                                                                                                                                                                                                    |                                       |             |            |                          |                      |                              |                                                                                                |
|----------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------|-------------|------------|--------------------------|----------------------|------------------------------|------------------------------------------------------------------------------------------------|
| 7                                                                                                  | Хөрсний бохирдол, техник нөлөөгөөр хөрс болон ургамалд сөргөөр нөлөөлөх | Шатах тослох материал асгаралтаас хөрсөнд бохирдол үүсч болзошгүй Шатах тослох материал алдагдсанаас хөрс бохирдуулж болзошгүй, түүнээс урьдчилан сэргийлэх талаар ажилчдад зөвлөмж, мэдээлэл өгөх | Нийт ажилчид                          | Тогтмол     | -          |                          |                      | 2025                         | MNS 5850:2019, “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| 8                                                                                                  |                                                                         | Хөрсөнд бохир нэвчдэггүй био жорлон суурилуулах                                                                                                                                                    | -                                     | 1           | 4500.0     |                          |                      | 2025                         | MNS 3297:1991, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин                                            |
| 9                                                                                                  |                                                                         | Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явахыг хориглосон таних тэмдэг бүхий самбар байрлуулах                                                                                                    | Үйлдвэр агуулахаас амрах байр хооронд | удаа        | 1 удаа     | 500.0                    |                      | 2025                         |                                                                                                |
| №                                                                                                  | Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл                                      | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ                                                                                                                                                    | Хамрах хүрээ                          | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ, мян.төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах хууль, журам, стандарт                                                               |
| Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ |                                                                         |                                                                                                                                                                                                    |                                       |             |            |                          |                      |                              |                                                                                                |
| 10                                                                                                 | Ургамал                                                                 | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс олон сам үүсэх, урамлан нөмрөгт сөрөг нөлөө үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор үйлдвэр, агуулахаас амрах байр хооронд зорчих замыг хусч сайжруулах            | Үйлдвэр агуулахаас амрах байр хооронд | -           | 4000.0     |                          |                      | 2025                         | Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай                                                     |
| 11                                                                                                 | Амьтан                                                                  | Орон нутгийн байгууллагатай хамтран Биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх                                                                                                                           | Мандах сум                            | ширхэг      | 50         | -                        | Дотоод төсөв         | 2025                         | Амьтны тухай хууль                                                                             |

ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

